



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/254

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Зорилтот жил болгон зарлах тухай” 15/05 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд Арвайхээр суманд шинээр байгуулах хүнсний ногооны хүлэмжийн цогцолборын усалгаанд шаардагдах 25 тн ус нөөцлөх сав худалдан авахад 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 10,000,000 (арван сая) төгрөгийг “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0491

D:My Doc. Zahiramj. Zasag darga